

БАРУУН-УРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 09 ДҮГЭЭР САРЫН ОНЦЛОХ МЭДЭЭ

Сэтгэл зүйн төвөөс тайлант сард 17 удаагийн сургалт зохион байгуулж, 500 орчин иргэн хамруулж, мэдээлэл, зөвлөгөө өглөө. Үүнд:

Тус албанаас 2024 суралцах эхчүүдэд “Бид байгууллаа. хийсэн бөгөөд 1 дүгээр ангийн хүүхдийн онцлог, эцэг эхчүүд хүүхдийн хүмүүжилд, сурах арга барилд хэрхэн хандах талаар ойлгот, мэдээллийг олгосон юм.



сумын 6-р багийн ажлын онд шинээр 1 дүгээр ангид элсэн сурагчид болон тэдний эцэг бэлэн үү” арга хэмжээг зохион Сургалтыг Сэтгэл зүйч Д.Оюун



Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын алба хаагч нарт Гамшгийн үеийн алба хаагчдын сэтгэл зүй ба стресс менежмент сургалтыг зохион байгуулав. Сургалтад танхимаар 40 алба хаагч, цахимаар 50-55 албан хаагч хамрагдаж, ойлголт мэдээлэл авсан.



Тус сумын 7 дугаар багийн эцэг, эх асран хамгаалагч нарт зориулан “хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо” сэдэвт сургалт зохион байгуулав. Сургалтад 20 эцэг, эхийн төлөөлөл оролцож, мэдээлэл, зөвлөгөө авлаа.

Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтран хүнсний талоны бараанд хамрагддаг зорилтод бүлгийн өрхийн 13-18 насны охидуудад "Охид нэгнээ хамгааалж дэмжицгээе" арга хэмжээг зохион байгуулав. Сургалтын хүрээнд эрүүл зөв хооллолт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, нийгмийн харилцаа хандлага, сэтгэл зүйн гэсэн таван төрлөөр мэдээлэл, зөвлөгөө өглөө.



Шүүхийн шийдвэрийн гүйцэтгэх газарт ял эдэлж буй хоригдлуудад "Харилцааны суурь чадвар ба стрессийг даван туулах арга зам" сургалтыг зохион байгуулав. Ял эдэлж буй хоригдлуудаас “Бернс Хөдөлгөөнт Хүн Мод Байшин” сэтгэц оншилгооны проктив тестийг авч, дүгнэлт танилцуулан, зөвлөгөө өгч, харилцан ярилцсан.



Сумын Засаг даргын

захирамжаар ажлын хэсэг томилогдон тус сумын 11 цэцэрлэгт хүүхэд хамгааллын багийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 09-ны өдрөөс 20-ны өдрийн хугацаанд хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгууллаа. Сургалтаар Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга танилцуулах, хуульд орсон нэмэлт өөрчлөлт, гамшиг онцгой нөхцөл байдлын үед хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх зураглал, хүүхэд гэр бүлийн эрсдэлийг тодорхойлох арга зүй, мөн сэтгэл зүйн зонхилон тохиолдох эмгэг, сэтгэл зүйн гэмтэлтэй хүүхдийг ирүүлэх арга зүй, Сэтгэл зүйн гэмтэлтэй хүүхэдтэй ажиллах урлагийн сэтгэл заслын хэрэглээ, эрт илрүүлэг кейсийг нээж ажиллах зэрэг сэдвээр мэдээлэл олгож, 11 цэцэрлэгийн 300 гаруй албан хаагч хамрууллаа.

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр халамжийн газрын алба хаагч нарт тус сумын Сэтгэл зүйн төвийн сэтгэл зүйч Д.Оюун “Сэтгэл зүйн зөвлөгөө ба стресс менежмент” сургалт зохион байгуулав. Сургалтын хүрээнд сэтгэл зүйн зөвлөгөө, ашиг тус, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хувь хүний аз жаргалын хэмжүүр, стресс менежмент хэвшүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн дадал зуршлын талаар мэдээлэл, зөвлөгөө өглөө.

Операторын үйлчилгээгээр 18 төрлийн лавлагааг 224 иргэнд гарган өгч, үйлчилсэн байна.

Үйлчилгээний нэгдсэн төвд операторын үйлчилгээ үзүүлж байгаа бөгдөөд тайлант сард иргэний үнэмлэхний лавлагаа-56, оршин суугаа хаягийн бүртгэл-33, төрсний бүртгэлийн лавлагаа, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт -25, шүүхийн шийдвэр бусдад өр төлбөргүй эсэх-17, үл хөдлөх хөрөнгийн лавлагаа-11, үл хөдлөх хөрөнгө өмчилж байгаа шилжүүлсэн эсэх лавлагаа-9, гэрэлсний бүртгэлийн лавлагаа-9, иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх-6, жолоочийн лавлагаа мэдээлэл-5, зээлийн мэдээллийн лавлагаа-4, иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх-4, гэрэлсний бүртгэлгүй лавлагаа-3, иргэнд олгох тодорхойлолт-3, мал тооллогын бүртгэлийн лавлагаа-2, өндөр настны тэтгвэр тогтооллын хуудас-2, кадастрийн зураг -1, эрүүл мэндийн даатгал төлөлт зэрэг нийг 18 төрлийн лавлагааг 224 иргэнд лавлагаа тодорхойлолт гаргаж өглөө. Үүнээс төлбөртэй үйлчилгээ-28, төлбөргүй үйлчилгээ-223, Тоон гарын үсгээр-116, портал системээр 135 төрлийн үйлчилгээг үзүүлсэн.

Хөрөнгө оруулалтын чиглэлээр: 2024 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу орон нутгийн хөгжлийн сангийн удирдлага мэдээллийн системд гүйцэтгэлийн дагуу бүрэн шивж байршуулсан. Мөн tender.gov.mn сайтаар 9 төсөл арга хэмжээг 11 удаагийн давтамжтай зарлан зохион байгуулсан.

<https://shilendans.gov.mn/> сайтад сар бүр, тухай бүр оруулах мэдээллийг тогтмол хуулийн хугацаанд байршуулсан. Нийт өссөн дүнгээр 43 мэдээлэл байршуулахаас 42 мэдээлэл хугацаандаа байршуулж 1 мэдээлэл хугацаа хоцорсон төлөвтэй 98 хувьтай байршуулсан байна.

Төсвийн тухай хуулийн дагуу 2024 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын саналыг иргэдээсээ авч эрэмбэлж, 2024 оны үндсэн чиглэл, мөрийн хөтөлбөртэй уялдуулан нийт 55 нэр төрлийн ажил, мөн урьд оны өрийг тусган 4,145.3 сая төгрөгийн ажил хийхээр төлөвлөж, ИТХ-аар батлуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Шууд худалдан авалтын журмаар 19, нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 4, харьцуулалтын аргаар 13 ажил өссөн дүнгээр зохион байгуулаад байна. Нийт ажлын гүйцэтгэл 30 хувьтай байна. Цахимаар 33 ажил зохион байгуулахаас 22 ажил tender.gov.mn сайтаар зарлан зохион байгуулаад байна. Нийт ажлын 65 хувийг зарлан зохион байгуулсан. Үүнд: 1. 5 дугаар багийн явган замын засвар, шинэчлэл, 2. 7 дугаар багийн явган замын засвар шинэчлэл, 3. Нийтийн тээвэр худалдан авах, 4. Хогны машин худалдан авах, 5. Гамшгийн мэргэжлийн ангид авто машин худалдан авах, 6. тоглоомын талбайн засвар шинэчлэлийн ажил, 7. худалдааны гудамжны тохижилтын ажил 8. 1-р тойргийн замын тэмдэг, тэмдэглэгээг байршуулах ажил 9. Инженерийн шугам сүлжээ тоног төхөөрөмж худалдан авах, 10. Цахилгаан шугамын хүчин чадлыг нэмэгдүүлэх 11. 9 дүгээр багийн тоглоомын талбай байгуулах зэрэг ажлуудыг 2-5 удаагийн давтамжтай зарлан зохион байгуулсан.

2023 орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийг аймгийн орон нутгийн хөгжлийн сан хариуцсан мэргэжилтэн А.Уянга үнэлгээ хийж баталгаажуулсан. Жилийн гүйцэтгэлийн үнэлгээний 35 үзүүлэлтийн дагуу сангийн яам 2023-2024 оны орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэлийг системд үнэлж 80 хувьтай үнэлэгдсэн. Удирдлага мэдээллийн системд 2024 оны 18 төсөл арга хэмжээний 685,2 сая төгрөгийн гүйцэтгэлийг шивж байршуулсан.

Засаг даргын захирамжаар байгуулсан үнэлгээний хороо нийт 9 ажлыг tender.gov.mn сайтаар зарлан зохион байгуулсан. Үүнд:

1. Нийтийн орон сууцны шугам сүлжээний засвар
2. Худалдааны гудамжны тохижилт
3. Тоглоомын талбайн засвар шинэчлэл
4. Авто машин худалдан авах /ГМА/
5. Авто машин худалдан авах /ГХУСА33/
6. Сурагч ширээ сандал нийлүүлэх, тоног төхөөрөмж худалдан авах
7. 1 дүгээр тойргийн авто замын тэмдэг тэмдэглэгээний ажил буюу нийт 7 ажлыг 11 удаагийн давтамжтай зохион байгуулж ажилласан.

Ерөнхий боловсролын 2,4 тухтай суралцах боломжийг хүртээмжийг нэмэгдүүлэх төгрөгийн санхүүжилтээр 9 ширээ, сандалыг худалдан авах



дүгээр сургуульд сурагчид тав бүрдүүлэх, анги танхимын зорилгоор 2024 онд 71 сая ангид 190 хос болон дан сурагч ажлыг зохион байгуулаад байна.

Байгаль орчин, хот тохижилтын чиглэлээр:Ногоон байгууламжийн усалгаа, арчилгааны багц тендер зарлагдаж, Шаргын модот цэцэрлэг ХХК шалгарч 9-н байршилд 7870 модыг услах, арчлах ажлыг гүйцэтгэж байна.

Иргэдийг ургамлын харшлаас урьдчилан сэргийлэх, хотын өнгө үзэмжийг сайжруулах, шарилж, хогийн ургамлыг устгах ажлын хүрээнд тус Тамгын газраас Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨҮГазарт 20,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Шарилж хогийн ургамалтэй тэмцэх, устгалын ажлын үр дүнг сайжруулах зорилгоор босоо-10, хэвтээ-4 тайрагч багаж хэрэгслээр сайжруулж, сумын 1,2,3-р тойрог дотор нийтийн эзэмшлийн зам талбайн хөл газрын ургамлын ургалтын хугацаанд 3-4 удаа тайрах ажлыг гүйцэтгэж байна.

Тус сумын 4, 6-р багийн нутаг дэвсгэрт хөрсний бохирдлыг бууруулах, иргэдийн эрүүл аюулгүй орчин нөхцөлд амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор нүхэн жорлонгийн ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажлыг сумын Засаг даргын А/245 тоот захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2024 оны 09-р сарын 07-ны өдрөөс 09-р сарын 19-ний өдрийг хүртэл хугацаанд хийлээ. Уг ажилд 4 албан хаагч, ДҮК машин-1, автомаск-4ш хэрэгсэлтэй ажиллан нийт-542 өрхийн нүхэн жорлонг био бэлдмэл, жавалины уусмалаар ариутган, халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж, 8,9 сая төгрөг зарцуулсан.

Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгууллаа.

Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газраас бүх нийтийн цэвэрлэгээг жилд 2 удаа тогтмол зохион байгуулж, нийт 8-н багийн 5000 гаруй өрх, 25 албан байгууллага, аж ахуй нэгж, нийт иргэд, төрийн албан хаагчдыг хамруулан зохион байгуулан цэвэрлэгээ хийж хоггүй орчинг бүрдүүлсэн.



3-р багийн өрхийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, жимс, жимсгэний аж ахуйг хөгжүүлэх зорилгоор Шаргын модот цэцэрлэг ХХК-тай гэрээ байгуулан 2 төрлийн 2500 ш өрөл, монос модны суулгацыг нийлүүллээ.

Иргэдийг ая тухтай, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангах зорилгоор дараах ажлуудыг хийлээ. Үүнд:

- 1, 3, 4-р багуудад босгох цамхагт гэрэлтүүлгийн ажлууд хийгдэж, шинээр 18ш цамхагт гэрэлтүүлэг босгон, гэрэлтүүлгийн асалтын тоог нэмэгдүүлсэн.
- Авто замын гэрэлтүүлгийн утас, гэрлийн шонгийн засвар, шийтний эвдрэлийг засварласан. Үүнд:
- Залуус хотхон 5-р байрны 1, 5 давхарын мэдрэгчтэй гэрэл, 48 айлын 2, 3-р орцны 4, 5 давхарын мэдрэгчтэй гэрэл шинээр солив. Цайрт хотхоны 3-р байрны гэрэл, Цэлмэг хотхоны 3-р байрны асахгүй байгаа автоматыг засварласан. Сурталчилааны самбарын аннасыг өлгөж тогтоох ажлыг гүйцэтгэж, 3 байгууллагын 4ш сурталчилгааны самбарыг өлгөж тогтоосон.
- Орон сууцны дээвэр, чардак, аваарын шатнаас хүүхэд унаж бэртэхээс сэргийлэн нийтийн эзэмшлийн орон сууцнуудын чардакыг цоожилж, бэхлэх, ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийт 6 байрны чардакны хаалгыг цоожилж, 6ш цоож шинээр хийсэн.
- Залуус хотхоны 4-р байрны 1-р орцны хаалгыг сольж суурилуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

- Тус байрны орцны оршин суугчдын өөрсдийн санаачлагаар орцны хаалгаа шинэчлэх зорилгоор айл өрхүүд нэгдэн чийптэй хаалга захиалан авчруулж, хаалганы амалгаа хийж суурилуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.
- Орон сууцны гадна пасадны засварыг эхлүүлж, Саруул хотхоны Хаан банкны байрны гадна пасад засварлах, тор татаж, шавардлага хийн гадна өнгийг сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэсэн.
- Даймонд хотхоны 105-р байрны 1 дүгээр орцны цэвэр усны нацоссыг 6 сард шинээр сольж тавьсан боловч 3 дахь удаагийн эвдрэл гарч, тус орцны усны нацосыг дахин солих шаардлагатай болсон тул Дөрвөлж Компанитай хамтран нацосыг шинээр тавьж суурилууллаа.
- Мандал хотхон 5-р байрны подволын шороог зөөж цэвэрлэн ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн.
- 27Б байрны 2-р орцны подвалын бохирын шугам задарч бохирын хоолойгоор сагасан ус, лагыг цэвэрлэх ажил хийгдсэн.

Нийгмийн хамгааллын чиглэлээр:

“Ахмад-2024” спортын олон төрлийн тэмцээн зохион байгуулагдлаа. Тэмцээнд 9 багийн 358 ахмад хурд хүч авьяас чадвараа сорьсноос 2-р шат буюу аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 116 ахмад тамирчин оролцож багийн дүнгээр тэргүүн багийг эзэлсэн.

2 дугаар багийн 210 ахмадын төлөөлөл болох 70 ахмад настныг оролцуулсан "Уртын голын ахмадууд" чуулга уулзалтыг ахмадын зөвлөлтэй хамтран амжилттай зохион байгууллаа. Тус чуулганд Д. Буянтгоо Үндэсний дээл хувцасаас, Л.Халтар /Алтан цацал хоршоо/ төмс хүнсний ногоо, Д.Гансүх 50,60,70аад оны бичиг баримтын үзэсгэлэнгээр тус тус оролцлоо.

Ахмад настнуудын дунд Агшин танин мэдэхүйн тэмцээнийг нийтийн номын сантай хамтран зохион байгуулж, чуулганд оролцогчдод дархлаажуулалтын багц олголоо.

Энэтхэг Улсын Вендалуру хотод зохион байгуулагдсан Олон Улсын Ази тивийн таеквондогийн 10 дахь тус сумын Ерөнхий сургуулийн сурагч М. Ивээл хүрэл медаль, 1-р сургуулийн Ундрага нар 11-13 насны хүртэж, улс, сум, орон өндөрт өргөсөн амжилт Засаг даргын Тамгын газар, зүгээс хоёр тамирчин хүлээн авч, хүндэтгэл үзүүллээ.



удаагийн тэмцээнд боловсролын 4-р нь 8-12 насны төрөлд сурагч Г. Мөнх-төрөлд хүрэл медаль нутгийнхаа нэрийг үзүүлсэн. Сумын сумын ИТХурлын

“Би сэлж сурлаа-ii” сургалтын аян “би сэлж сурлаа -ii” 3 сарын богино хэмжээний түргэвчилсэн 20-оос эхлэн 12 сарын 20-ыг аймгийн биеийн тамир ажиллах гэрээг байгуулан жилийн сургалтад усан сонирхолтой цэцэрлэгийн



сургалт 2024 оны 9 сарын хүртэл үргэлжлэхээр спортын газартай хамтран ажиллаж байна. Энэ спортоо хичээллэх 4,5-н насны 30 хүүхэд,

Ерөнхий боловсролын сургуулийн 6-18 насны 120 хүүхэд бүртгэн 3 сарын хугацаанд мэргэжлийн багштай хичээллүүлэн үр дүнг гарган ажиллана.

Боловсролын чиглэлээр: Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж дэмжлэг үзүүлэх журам"-ын дагуу аймаг, нийслэл дүүргийн хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлын ерөнхий төлөвлөгөөг хангах ажлыг хэрэгжүүлэх түргэвчилсэн үнэлгээний дагуу сумын хэмжээнд 2024 оны 8 дугаар сарын 2,3 -ны өдрүүдэд орсон үеэр усны улсаар 33 өрх усанд автаж байгалийн давагдашгүй нөхцөл байдал орсон. Тус өрхүүдэд нийт 76 хүүхдэд эрсдэлийн үнэлгээг хийж аймгийн гэр бүл хүүхэд хамгааллын газарт судалгаа үнэлгээг хүргүүлэн дэмжлэг үзүүлсэн.

Сум, багийн хамтарсан баг тус 76 хүүхдэд кейс нээж хариу үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлэн ажиллаж байна.

Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 2 дугаар бүрэн дунд сургуульд насан туршийн боловсролын төвийн суралцахуйн төвийг 2024-2025 оны хичээлийн жилд нээж тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүдийг сургах орчин нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Энэ хичээлийн жилд тус сургалтын төвд 2 багш 17 хүүхэдтэй хичээллэж байна.

Сумын хэмжээнд 2024-2025 оны хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй 2-18 насны 98 хүүхэд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт хамрагдахаас зорилтот бүлгийн 20 хүүхдэд хичээлийн хэрэглэгдэхүүн худалдан авахад зориулан 100,000 төгрөгийн дэмжлэг үзүүлэн, эрхийн бичиг гардууллаа. Энэхүү ажлыг тус Тамгын газраас 4 дэх жилдээ хэрэгжүүлж байгаа бөгөөд нийт 75 хүүхдэд 7,500,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

"Угийн бичиг -Удмын хэлхээ" нэг сарын аяныг удирдамж төлөвлөгөөний дагуу зохион байгуулан ажиллаж байна. Үр дүн нь шинээр 270 өрх угийн бичиг хөтөлж эхэлсэн байна. Мөн ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад угийн бичиг хөтлөлтийн талаар мэдээлэл өгсөн.

“Найрсаг Баруун-Урт Театр” өдөрлөг зохион байгуулагдлаа.

Сумын Засаг даргын 2024 оны А/223 тоот захирамжаар “Найрсаг Баруун-Урт Театр” өдөрлөгийг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан, ажлын төлөвлөгөө, хөтөлбөр, удирдамжийг Тамгын газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Төрийн үйлчилгээг иргэдэд сурталчлан таниулах төр иргэний хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “Найрсаг Баруун-Урт Театр” өдөрлөгийг 2024 оны 09 дүгээр сарын 11-13-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Өдөрлөгийг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, дараах арга хэмжээг хэрэгжүүллээ. Үүнд:

Улаанбаатар хотоос сэтгэл зүйч Г.Наранбаатарыг урин “Нөлөөллийн код” “Тогтвортой гэр бүлийн харилцаа тогтвортой жил амьдралын үндэс” 2 удаагийн сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулсан.



2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 10:00 цагт “Нөлөөллийн код” чадавхжуулах сургалтыг Ерөнхий боловсролын сургуулийн Нийгмийн ажилтан, Сэтгэл зүйч, Сүхбаатар аймгийн цагдаагийн газрын сэтгэл зүйч, Хүүхэд гэр бүл хөгжил

хамгааллын
мэргэжилтэн,
тус сумын
хэмжээнд
дадлага хийж
буй сэтгэл
судлаач,
оюутнууд зэрэг
21 хүнийг
сургалтад



хамруулсан. Чадавхжуулах сургалтаар сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, мэргэжилтнүүдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сэтгэл зүйн зөвлөгөөний арга зүй, хомсдлын сэтгэл зүй, стресс менежмент, илтгэх урлагийн арга техник, амиа хорлолт донтолтын сүүлийн жилүүдэд хийгдсэн судалгааны үр дүнг танилцуулсан бөгөөд мэргэжилтэн сэтгэл зүйч нийгмийн ажилтан нарыг чадавхжуулах зорилготой зохион байгуулагдсан.

Мөн өдрийн 14.00 цагаас тус сумын иргэдэд зориулан “Тогтвортой гэр бүлийн харилцаа тогтвортой жил амьдралын үндэс” лекцыг аймгийн ХЖТ-т зохион байгуулж, 400 орчим иргэнд хүргэлээ. Лекцын агуулга хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, ажил, амьдралаа хэрхэн тэнцвэртэй хадгалж авч явах вэ?, гэр бүлийн үндэс, тогтвортой харилцааны талаар үнэтэй мэдээлэл, зөвлөгөө өгсөн сайхан лекц болсон.

Спортын клуб, холбоодод спорт хэрэглэгдэхүүний дэмжлэг үзүүллээ. “Баруун-Урт сумын ИТХ-ын 2021 оны 04/09 тоот тогтоолоор “Зөв хэвшил-зөв амьдрал” хөтөлбөрийг батлуулан

- 2021 онд “Архигүй, амар тайван хот уриалга ,
- 2022 онд "Идэвхтэй хөдөлгөөнөөр эрүүл мэнд"
- 2023 онд “Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх” төв байгуулах
- 2024 онд Электрон тамхины хэрэглээ, түүний хор уршиг, эрүүл хооллолт чиглэлээр үйл ажиллагаа, сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж,

хөтөлбөр хаалтаа хийлээ. 4 дэх жилдээ амжилттай хэрэгжсэн тус хөтөлбөрийн хаалтын үйл ажиллагааны үеэр Баруун-Урт сумын хүүхэд, залуучуудыг спортоор хичээллэх, эрүүл чийрэг бие бялдартай болгон төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор тогтмол үйл ажиллагаа явуулдаг спортын клуб холбоодод хэрэглэгдэхүүний дэмжлэг үзүүллээ. Тухайлбал :

Сур харваа, Жу-до бөх, Усан спорт, Хөлбөмбөг, Чөлөөт бөх, Аэробик гимнастик, Волейбол, Сагсан бөмбөг, Хөнгөн атлетик, Бокс, Дугуй, Шатар, даам, софт волейбол, такевондо нийт 14 спортын клуб холбоодод 13.0 сая төгрөгийн



дэмжлэг үзүүлсэн.Үүнд:

- **Чөлөөт бөхийн холбоо** Ц. Энхбат-Борцок-5 ш,Тирко-5 ш
- **Жу-до бөхийн холбоо** А. Сувд-Эрдэнэ-Бэлтгэлийн кимоно -2 ш, Самбын курттик – 2 ш
- **Сагсан бөмбөгийн холбоо** Ц. Ганбат-Сагсан бөмбөг – 10 ш
- **Волейболын холбоо** А. Ганхүү-Бөмбөг - 10 ш
- **Хөл бөмбөг** Э. Энхтунгалаг-Бөмбөг – 10 ш
- **Хөнгөн атлетикийн холбоо** Ө. Энэбиш-Шипи -10 ш, Тууз – 1 ш
- **Дугуйн спортын холбоо** С. Төмөрхуяг-Giant Дугуйны гадар хаймар 700x25с – 2 ш, Giant Дотор хаймар 700x25с – 4 ш, Giant-Look зуувч -1 ш, Shimano-зуувч – 2 ш, Giant-пулийн оролт – 3 ш, KMC-11 арааны гинж – 2 ш, CCN-дэгтий – 4 ш
- **Шатрын клуб** Компьютер -2 ш,Принтер – 2 ш
- **Усан спорт** Ч. Соёлмаа- Хөвөгч хантааз -20 ш, Хөвөгч цагариг -10 ш
- **Аэробик гимнастик** Н. Болортуяа-Степ -8 ш, Уран сайхны хувцас -5 ш
- **Бокс клуб** Ма Мөнхжаргал-Бөмбөг – 5 ш,Толгойны хамгаалалт – 4 ш, Эмзэг эрхтний хамгаалалт-3 ш
- **Жюу – жицү клуб** А. Мөнхжаргал-ги А1, А2 – 2 ш
- **Сур харваа холбоо** Л. Одсайхан, Хасаа – 60 ш,Сум үүтгэр – 1 багц, Булцуу, багц, Павунт хэмжигч - 2 ш тус тус олголоо.

Баруун-Урт даргын Тамгын газраас спортоор хичээллэн, тэмцээнд оролцоход зорчих боломжоор автобусыг аймгийн спортын газарт Тус автобус нь 24 онд үйлдвэрлэгдсэн, орж ирсэн бөгөөд



сумын ИТХ, Засаг хүүхэд, залуусыг бүс, улсын уралдаан аюулгүй, тухтай хангаж хүүхдийн Биеийн тамир гардуулан өглөө. хүний суудалтай 2018 2024 онд Монголд нээлттэй тендер

шалгаруулалтын аргаар зохион байгуулж тендерт Фленти трейд ХХК 119,8 сая төгрөгийн үнийн саналаар шалгарч нийлүүлсэн юм.

Хүүхдийн автобусыг Уртын гэгээ ОНӨААТҮГазар хариуцах бөгөөд спортын холбоод тэмцээн уралдаанд явахдаа ашиглана.

Ахмадуудын дунд 2 төрлийн спортын тэмцээн зохион байгуулсан.Үүнд:

Софт волейболын тэмцээнд 9 багийн 54 ахмад оролцсон бөгөөд эхний байрт

Софт волейбол 50-59, 59-65 нас холимог

1-р байр Ц. Пүрэвдорж ахлагчтай 1 дүгээр баг

2-р байр Ө. Амартайван ахлагчтай 7 дугаар баг

3-р байр Ч. Пүрэвдорж ахлагчтай 2 дугаар баг

Софт волейбол 60+, 65+ нас холимог

1-р байр Д. Чойжилсүрэн ахлагчтай 3 дугаар баг

2-р байр Н. Өлзийсайхан ахлагчтай 7 дугаар баг

3-р байр Ч. Баярцогт ахлагчтай 1 дүгээр баг



Шугаман бүжгийн тэмцээнд нийт 6-н багийн 40-н оролцогч сугалаа ёсоор номероо амжилттай үзүүлээ.

Тус тэцээний онцлог нь хамгийн өндөр настай 73 настай оролцогч 6-р багийн



иргэн Б.Саарал, хамгийн залуу оролцогч 50 настай 7 дугаар багийн иргэн Д.Болортуяа, мөн хамгийн олон оролцогчтой буюу 12 хүний бүрэлдэхүүнтэй 3-р баг байлаа. Шугаман бүжгийн тэмцээний эхний 3 байр шалгаруулсан. Үүнд:

1 дүгээр байранд 3 дугаар баг /Ц.Цэцгээ ахлагчтай

2 дугаар байранд 2 дугаар баг /Б.Туул ахлагчтай/

3 дугаар байранд 6 дугаар баг /Б.Саарал ахлагчтай/ багууд тус тус байр эзэллээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгуулсан гүйлтийн



тэмцээнд 7 багийн 20 иргэн оролцсон бөгөөд эхний байруудыг дараах иргэд эзэллээ.Үүнд:

100 метр гүйлт эмэгтэй

1-р байр Г. Амаржаргал 7 –р баг

2-р байр Г. Урансайхан 5 –р баг

3-р байр С. Эрдэнэ 2 –р баг

100 метр гүйлт эрэгтэй

1-р байр Г. Гансүх 7 –р баг

2-р байр Д. Гантулга 5 –р баг

3-р байр С. Хишигбаатар 1 –р баг

400 метр гүйлт эмэгтэй

1-р байр А. Сумьяагарав 3 –р баг

2-р байр О. Баяраа 7 –р баг

3-р байр Ү. Гэрэлмаа 5 –р баг

400 метр гүйлт эрэгтэй

1-р байр С. Ариунболд 1 –р баг

2-р байр Э. Очирсүх 4 –р баг

3-р байр Б. Батбаяр 2 –р баг

Залуучуудын дунд 5 төрлийн спортын тэмцээн зохион байгуулж, 9 багийн 280 гаруй иргэн оролцсон. Үүнд:

Дартс тэмцээний төрөл

1-р байр Б. Буянбадрах ахлагчтай 1-р баг

2-р байр Г.Төрхүү ахлагчтай 7-р баг

3-р байр Д. Гантөмөр ахлагчтай 8-р баг

Модон барилдаан +70 жин эмэгтэй

1-р байр Э. Энхтунгалаг 6-р баг

2-р байр Ч. Соёлмаа 7-р баг

3-р байр Д. Цэцэнзаяа 3-р баг

Модон барилдаан +70 жин эрэгтэй

1-р байр Д. Ганбаатар 3-р баг

2-р байр О. Энхбаяр 1-р баг

3-р байр А. Үүрцайх 4-р баг

Модон барилдаан -70 жин эмэгтэй

1-р байр И. Энхсарнай 1-р баг

2-р байр Б. Нандинчимэг 9-р баг

3-р байр Б. Алтанзул 7-р баг

Модон барилдаан -70 жин эрэгтэй

1-р байр У. Данзансүрэн 6-р баг

2-р байр Э. Эрдэнэбаатар 9-р баг

3-р байр Э. Баасанпүрэв 3-р баг

Олс таталт

1-р байр

2-р байр

3-р байр

Сагсан бөмбөг 5х5 - Эмэгтэй

1-р байр А. Болорчимэг ахлагчтай 2-р баг

2-р байр Б. Мөнхчимэг ахлагчтай 7-р баг

3-р байр Н. Сувд-Эрдэнэ ахлагчтай 9-р баг

Сагсан бөмбөг 5х5 - Эрэгтэй



1-р байр М. Мөнхсүх ахлагчтай 7-р баг
 2-р байр Б. Мөнх-Очир ахлагчтай 2-р баг
 3-р байр Г. Өлзийсайхан ахлагчтай 5-р баг
Волейбол - Эмэгтэй
 1-р байр Г. Өлзийцэцэг ахлагчтай 7-р баг
 2-р байр С. Уртнасан ахлагчтай 6-р баг
 3-р байр Т. Долгормаа ахлагчтай 1-р баг

Волейбол - Эрэгтэй

1-р байр Г. Батсугар ахлагчтай 1-р баг
 2-р байр М. Хадхүү ахлагчтай 7-р баг
 3-р байр Б. Гантулга ахлагчтай 9-р баг
Шилдэг багаар 7 дугаар багийн ажлын алба шалгарч цомын эзэн боллоо.



Хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, үндэсний үйлдвэрлэгчдийн шилдэг бүтээгдэхүүн, эх орны хөрсөнд ургасан шинэ ургацын дээжийг хэрэглэгчдэд шууд нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Найрсаг Баруун-Урт театр өдөрлөг хүрээнд үзэсгэлэн худалдаа хоёр



өдөр

зохион

байгуулсан.

Үзэсгэлэн худалдаа 2024 оны 09 дүгээр сарын 12,13-ны өдрүүдэд төв талбайд зохион байгуулагдлаа. Уг үзэсгэлэн худалдаанд 9 багийн 36 аж ахуй нэгж, иргэн оролцож, өөрсдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн хүнсний ногоог худалдаалж 2 өдрийн турш 16.100.000 төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллалаа. Орон нутгийн бренд бүтээгдэхүүн, Шилдэг өрхийн үйлдвэрлэгч, Шилдэг гурилан бүтээгдэхүүн, Шилдэг өрхийн үйлдвэрлэгч, Шилдэг модон бүтээгдэхүүн, Шилдэг тариаланч гэсэн 6 номинациар шилдэгээ тодрууллаа. Үүнд:



Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид

Шилдэг брэнд бүтээгдэхүүн

1-р байр Б. Өлзийтогтох / Талын борц / 1-р баг
 2-р байр Ч. Энхчулуун / Арьсан эдлэл / 2-р баг

Шилдэг өрхийн үйлдвэрлэгч

1-р байр П. Эрдэнэчимэг / Оёдол / 6-р баг
 2-р байр П. Азаяа / Давсан урлал / 1-р баг

Шилдэг модон бүтээгдэхүүн үйлдвэрлэгч

1-р байр С. Лхасүрэн / Авдар, хазаарын өлгүүр / 7-р баг

Шилдэг гурилан бүтээгдэхүүн

1-р байр М. Оюунгэрэл / Оранж бэкери / 7-р баг

2-р байр Э. Энх-Оргил / Оргил бэкери / 7-р баг

Шилдэг хүнсний ногоо үйлдвэрлэгч

1-р байр Ч. Болормаа 7-р баг

2-р байр Л. Халтар / Алтан цацал хоршоо / 2-р баг

Эрүүл – эко хоол үйлдвэрлэгч

1-р байр П. Сайханчулуун Үүлэн ресторан 1-р баг

2-р байр Р. Мичидмаа / Зөөврийн түргэн хоол / 1-р баг

“Найрсаг Баруун-Урт Театр” өдөрлөгийн 3 дахь өдөр буюу 09 дүгээр сарын 13-ны аймгийн Татварын газар, аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Энхлэн ачтан, Энэрэл ачтан өрхийн эрүүл мэндийн төв, аймгийн Эрүүл мэндийн газар зэрэг байгууллагууд өдөрлөгт оролцон тус сумын хүн амд өөрийн байгууллагын үйл ажиллагаа болон хэрэгжүүлж буй хууль тогтоомжийг сурталчлан таниулж, сургалт мэдээлэл өгч, хамтран ажиллалаа.

Өдөрлөгийн хаалтын үйл ажиллагааг Сүхбаатарын төв талбайд 17.00-20.00 цагийн хооронд зохион байгуулж, аймгийн ХЖТ-ын урлаг, соёлын тоглолт болж, спортын клуб, холбоодод спорт хэрэглэгдэхүүн, хүүхдийн автобусыг аймгийн Биеийн тамир спортын газарт тус тус гардуулан өглөө. Мөн өдөрлөгийн хүрээнд хүрээнд зохион байгуулсан тэмцээн уралдаанд амжилттай оролцсон баг тамирчдад шагнал гардуулах үйл ажиллагаа болж, өндөрлөв.

Хүнс хөдөө, аж ахуйн чиглэлээр:

Аймгийн Засаг даргын А/516 дугаар захирамжийн дагуу “Намрын ногоон өдрүүд-Сүхбаатарт үйлдвэрлэв-2024” арга хэмжээ үзэсгэлэн худалдаа 2024 оны 09 дүгээр сарын 20-21-ний өдрүүдэд төв талбайд зохион байгуулагдлаа. Уг үзэсгэлэн худалдаагаар малчид, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээллийг олон нийтэд танилцуулах, үйл ажиллагааг нь дэмжин хөгжүүлэх, харилцан туршлага солилцуулах, сумын шилдэг бүтээгдэхүүн, үйлчилг

ээг бий болгох эх орны хөрсөнд ургасан шинэ ургацын дээжийг хэрэглэгчдэд нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нийт 9 багийн 36 аж ахуй нэгж, иргэн оролцсон. Мөн 6 малчин шилмэл малын үзэсгэлэнд оролцлоо.

Өөрсдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн хүнсний ногоог худалдаалж 2 өдрийн турш нийт 28.020.000 төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан бөгөөд дараах амжилтыг үзүүллээ. Үүнд:

Стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн төрөлд :
-Ч.Энхчулуун Тэргүүн байр



Хөнгөн үйлдвэрийн шилдэг бүтээгдэхүүн-Х.Наранчимэг/дэд байр/

Шилдэг хоол үйлдвэрлэгч- Х.Мичидмаа/тэргүүн байр/

Сүүний чиглэлийн үхэр хээлтэгч-Х.Батнасан /тэргүүн байр/

Сүүний чиглэлийн үхэр хээлтүүлэгч –Х.Батнасан/ тусгай байр/

Сүүний чиглэлийн хээлтүүлэгч-Шавхагдашгүй баялаг ХХК/дэд байр/

Махны чиглэлийн-Б.Дашням /тэргүүн байр/

Махны чиглэлийн-Б.Дашням /гутгаар байр/

Махны чиглэлийн бух- Шавхагдашгүй баялаг ХХК/гутгаар байр/ тус тус эзэлж, Баруун-Урт сум багийн дүнгээр Тэргүүн байр эзэллээ.

Монголын Эмэгтэйчүүдийн холбоо үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой , " 1000 ЭЭЖИЙН БАЯР"-ын арга хэмжээ 9 дугаар сарын 20-ны өдөр Баруун-Урт хотноо Сүхбаатар аймгийн эмэгтэйчүүдийн холбоотой хамтран зохион байгууллаа.

Тус арга хэмжээнд 12 сум , Баруун-Урт сумын9 багаас, салбар салбарын , нас насны төлөөлөлийн мянган эмэгтэйчүүд оролцож, нэгэн өдрийг хайртай ээжийгээ баярлуулах, хамтдаа мэдлэг мэдээлэл авах , ахмадууддаа хүндэтгэл үзүүлэх, гэр бүл, хамтын амьдрал, хайрын талаар лекц сонсож, харилцан бие биенээсээ суралцах, үүх түүхээ хүүрнэлдэн сайн сайхан ирээдүй, эмэгтэйчүүдийн оролцоо, нөлөөлөл ямар байх талаар хэлэлцэн ярилцсан, үр дүнтэй арга хэмжээ боллоо .

"1000 ээжийн баяр " мянган ээжийн сүүн цацалаар эхэлж, “Спорт цогцолборт” ойн нэгдсэн хуралдаан, үе үеийн удирдлагууддаа хүндэтгэл үзүүлэх, “Хайрлагдсан эмэгтэй ” лекц, үдшийн цэнгүүнээр үргэлжилсэн юм.



ТАЙЛАН БИЧСЭН:
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

А.ӨЛЗИЙЖАРГАЛ